



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 6/ОН

Чингис хот

Т.Бямбадуламыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" 275 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Төмөрбаатарын Бямбадуламыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд 2023 оны 1 дүгээр сарын 02-оос эхлэн томилсугай.

2.Т.Бямбадуламын үндсэн цалинг ТЗ-6-5 шатлалаар тогтоон, 853,375 (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав) төгрөгөөр тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Т.Бямбадуламд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР